

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: naranbayar@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК

Захирал: Ж.Баяртуул

Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogrressaudit@gmail.com

Аудитор: Г.Гантуяа

Утас: 99060147, Цахим хаяг: platinumprogrressaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

᠒᠐᠒5.0᠗.17 № 03.

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502012

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>201,361,520.56</u> | <u>227,611,787.67</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 87,463,935.36 | 100,709,242.47 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 87,463,935.36 | 100,709,242.47 |
| 3121 | Төгрөг | 87,463,935.36 | 100,709,242.47 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 87,463,935.36 | 92,709,242.47 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | | 8,000,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 2,721,114.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 2,721,114.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 113,897,585.20 | 124,181,431.20 |
| 351 | Түүхий эд материал | 143,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 143,000.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 113,754,585.20 | 124,181,431.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 123,200.00 | 174,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,000.00 | 217,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,731,210.40 | 7,011,560.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 108,875,174.80 | 116,778,570.80 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | - | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>662,613,924.95</u> | <u>629,463,055.00</u> |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | - | - |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 662,613,924.95 | 629,463,055.00 |
| 392 | Биет хөрөнгө | 640,682,424.95 | 607,539,055.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 787,600,000.00 | 787,600,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (189,240,000.00) | (230,250,000.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 53,470,807.00 | 66,655,249.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,883,888.81) | (27,195,625.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,160,682.00 | 27,640,682.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,425,175.24) | (16,911,250.76) |
| 393 | Биет бус хөрөнгө | 21,931,500.00 | 21,924,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,220,000.00 | 1,220,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,212,500.00) | (1,220,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,924,000.00 | 21,924,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>863,975,445.51</u> | <u>857,074,842.67</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>791,701.19</u> | <u>1,512,000.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 791,701.19 | 1,512,000.00 |
| 413 | Өглөг | 791,701.19 | 1,512,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 327,011.19 | - |
| 4136 | Бусад өглөг | 464,690.00 | 1,512,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 464,690.00 | 1,512,000.00 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>863,183,744.32</u> | <u>855,562,842.67</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 863,183,744.32 | 855,562,842.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 21,924,000.00 | 21,924,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 21,924,000.00 | 21,924,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 841,259,744.32 | 833,638,842.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 768,671,433.49 | 841,259,744.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 72,588,310.83 | (7,620,901.65) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>863,975,445.51</u> | <u>857,074,842.67</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 725,785,100.00 | 962,192,342.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 45,986,500.00 | 27,614,442.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 45,916,500.00 | 27,614,442.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 45,916,500.00 | 19,614,442.80 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 45,916,500.00 | 19,614,442.80 |
| 120009 | Бусад орлого | - | 8,000,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 70,000.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 70,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 679,798,600.00 | 934,577,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 631,588,600.00 | 882,472,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 882,472,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 631,588,600.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 105,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 105,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 48,210,000.00 | 52,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,210,000.00 | 52,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 647,703,450.96 | 969,813,244.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 647,703,450.96 | 969,813,244.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 643,145,851.50 | 961,446,983.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 408,535,294.47 | 670,845,958.80 |
| 210101 | Үндсэн цалин | 238,675,405.10 | 420,390,490.13 |
| 210102 | Нэмэгдэл | 135,553,823.97 | 201,739,859.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,331,994.84 | 18,471,429.36 |
| 210104 | Урамшуулал | 19,974,070.56 | 30,244,180.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,843,861.43 | 82,893,680.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,259,606.30 | 56,912,878.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,372,892.81 | 6,695,834.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,066,042.70 | 3,321,979.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 920,616.90 | 3,223,913.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,224,702.72 | 12,739,074.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,237,011.19 | 43,588,228.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,577,660.09 | 8,759,572.15 |
| 210302 | Түлш, халаалт | 31,999,607.10 | 31,629,207.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,659,744.00 | 3,199,449.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,413,524.00 | 4,407,704.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,413,524.00 | 4,407,704.00 |
| 2105 | Нормативт зардал | 62,754,005.00 | 77,380,340.00 |
| 210502 | Хоол, хүнс | 62,754,005.00 | 77,380,340.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,300,000.00 | 6,140,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,300,000.00 | 6,140,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,025,800.00 | 1,489,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,512,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 513,800.00 | 1,489,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,036,355.41 | 74,701,872.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,431,980.00 | 11,567,030.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,950,050.00 | 8,319,530.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 49,654,325.41 | 54,815,312.75 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,557,599.46 | 8,366,260.66 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,557,599.46 | 8,281,500.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,557,599.46 | 8,281,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 84,760.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 84,760.66 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 78,081,649.04 | (7,620,901.65) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,493,338.21 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,493,338.21 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (5,493,338.21) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 72,588,310.83 | (7,620,901.65) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 679,868,600.00 | 942,577,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 70,000.00 | 8,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 8,000,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 8,000,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 70,000.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 70,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 679,798,600.00 | 934,577,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 631,588,600.00 | 882,472,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 882,472,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 631,588,600.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 105,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 105,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 48,210,000.00 | 52,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,210,000.00 | 52,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 605,950,025.36 | 924,073,292.89 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 605,950,025.36 | 924,073,292.89 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 601,392,425.90 | 915,707,032.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 408,535,294.84 | 673,567,072.80 |
| 210101 | Үндсэн цалин | 238,675,405.10 | 420,390,490.13 |
| 210102 | Нэмэгдэл | 135,553,824.34 | 204,460,973.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,331,994.84 | 18,471,429.36 |
| 210104 | Урамшуулал | 19,974,070.56 | 30,244,180.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,843,861.06 | 82,893,680.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,259,606.30 | 56,912,878.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,372,892.81 | 6,695,834.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,066,042.70 | 3,321,979.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 920,616.90 | 3,223,913.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,224,702.35 | 12,739,074.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,910,000.00 | 43,915,239.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,250,648.90 | 9,086,583.34 |
| 210302 | Түлш, халаалт | 31,999,607.10 | 31,629,207.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,659,744.00 | 3,199,449.00 |
| 2105 | Нормативт зардал | 64,968,420.00 | 79,788,190.00 |
| 210502 | Хоол, хүнс | 64,968,420.00 | 79,788,190.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,300,000.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,300,000.00 | 8,000,000.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,313,800.00 | 1,794,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,313,800.00 | 1,794,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,521,050.00 | 25,748,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,317,000.00 | 17,468,720.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,204,050.00 | 8,279,930.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,557,599.46 | 8,366,260.66 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,557,599.46 | 8,281,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,557,599.46 | 8,281,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 84,760.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 84,760.66 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>73,918,574.64</u> | <u>18,504,607.11</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 5,259,300.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 5,259,300.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 5,259,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 5,259,300.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | = | <u>(5,259,300.00)</u> |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 73,918,574.64 | 13,245,307.11 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 13,545,360.72 | 87,463,935.36 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 87,463,935.36 | 100,709,242.47 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|--|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,924,000.00 | 768,671,433.49 | 790,595,433.49 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,924,000.00 | 768,671,433.49 | 790,595,433.49 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | 72,588,310.83 | 72,588,310.83 |
| 8 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,924,000.00 | 841,259,744.32 | 863,183,744.32 |
| 9 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 21,924,000.00 | 841,259,744.32 | 863,183,744.32 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 11 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,924,000.00 | 841,259,744.32 | 863,183,744.32 |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - |
| 13 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - |

| | | | | |
|----|---|----------------------|-----------------------|----------------|
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | - |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | (7,620,901.65) | (7,620,901.65) |
| 17 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,924,000.00 | 833,638,842.67 | 855,562,842.67 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,021,037,200.00 | 929,247,832.23 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,021,037,200.00 | 929,247,832.23 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,012,755,700.00 | 920,966,332.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 749,361,000.00 | 673,567,072.80 |
| 210101 | Үндсэн цалин | 512,063,900.00 | 420,390,490.13 |
| 210102 | Нэмэгдэл | 230,487,900.00 | 204,460,973.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 18,471,429.36 |
| 210104 | Урамшуулал | 6,809,200.00 | 30,244,180.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,995,100.00 | 82,893,680.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,838,200.00 | 56,912,878.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,038,200.00 | 6,695,834.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,519,700.00 | 3,321,979.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,519,700.00 | 3,223,913.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,079,300.00 | 12,739,074.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,000,000.00 | 43,915,239.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,240,000.00 | 9,086,583.34 |
| 210302 | Түлш, халаалт | 31,630,000.00 | 31,629,207.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,130,000.00 | 3,199,449.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | - |
| 2105 | Нормативт зардал | 87,686,600.00 | 79,788,190.00 |
| 210502 | Хоол, хүнс | 87,686,600.00 | 79,788,190.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,677,200.00 | 2,673,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,677,200.00 | 2,673,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,035,800.00 | 30,128,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,751,300.00 | 21,848,620.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,284,500.00 | 8,279,930.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,281,500.00 | 8,281,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,281,500.00 | 8,281,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,281,500.00 | 8,281,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,021,037,200.00 | 934,493,139.34 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 882,472,900.00 | 882,472,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 882,472,900.00 | 882,472,900.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 52,000,000.00 | 51,915,239.34 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 52,000,000.00 | 51,915,239.34 |

| | | | |
|---------|--|---------------|---------------|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 86,564,300.00 | 105,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 105,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 86,564,300.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 87,463,935.36 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 92,709,242.47 |

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,282.7 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг завсрын аудитын явцад бүрэн залруулсан.

Аудитаар нийт 410.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт өгсөн.

Завсрын аудитын талаар

2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 3 зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

- Зургаан ажилтны ээлжийн амралтыг 708,6 мянган төгрөгөөр дутуу, дөрвөн ажилтны ээлжийн амралтыг 144.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, томилолтын тооцооны хуудас тамга дутуу үед 220.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон
- Он дамжсан 209.5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа үндсэн бус ажилтанд /эмчид/ 410,400.00 (Дөрвөн зуун арван мянга дөрвөн зуун) төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84.4-т “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн бус орон тооны ажилтанд олгосон үр дүнгийн урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

